

“ЭМ ЭН ДИ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 03 сарын 18-ны өдөр

Дугаар: 02/22

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

ЭМ ЭН ДИ ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал-ыг зарлан хуралдуулах асуудлыг хэлэлцээд Компанийн тухай хуулийн 59 дугаар зүйлийн 59.1, 59.4, 59.11 дахь заалт, 60 дугаар зүйл, 62 дугаар зүйл, 64 дүгээр зүйл, 67 дугаар зүйлийн 67.1 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.2, Санхүүгийн зохицуулах хорооны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам” бусад холбогдох заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эм Эн Ди” ХК-ний хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2022 оны 04-р сарын 28-ны 15:00 цагт Жаргалан хотхон хаус 24-т хурлын танхимд хуралдуулахаар тогтоосугай.
2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэхээр баталсугай. Үүнд:
 - 2.1. Компанийн 2021 оны бизнесийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын тайланг танилцуулах
 - 2.2. Компанийн ноогдол ашиг тараахгүй байх тухай танилцуулга
 - 2.3. Компанийн 2022 оны үйл ажиллагааны зорилтын тухай
 - 2.4. Компанийн ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийг сунгах тухай
 - 2.5. Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд болон тэдгээрийн эзэмшилд байгаа хувьцааг хуваах замаар, хувьцааны тоог нэмэгдүүлэх тухай санал
3. Санхүүгийн зохицуулах хорооны журмын дагуу “Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг Хавсралт № 1 баталж, 2022 оны 03 дугаар сарын 21-ны өдрийн дотор багтаан Санхүүгийн зохиуцлах хороо болон Монголын Хөрөнгийн Биржид хүргүүлсүгэй.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжилт хурлын зарыг Хавсралт № 2 -оор баталж, 2022 оны 03-р сарын 22-ны өдөр Монголын хөрөнгийн бирж болон өдөр тутмын сониноор дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх, мөн 2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр анх мэдээлсний дагуу дахин хурлын зарыг хүргэхээр тогтоосугай.

5. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичгийг 2022 оны 03 сарын 23-ний өдрийн дотор брокер диллерийн компанид цахим хэлбэрээр хүргүүлсүгүй.
6. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2022 оны 04 сарын 06-ны өдөр байхаар тогтоосугай.
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжилт хуралд биечлэн оролцох боломжгүй, саналын хуудсаар дамжуулан урьдчилан саналаа ирүүлсэн хувьцаа эзэмшигчдийг хуралд оролцсон гэж үзэх бөгөөд саналын хуудсыг хүлээн авах сүүлийн хугацааг 2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 18:00 цаг хүртэл тогтоосугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Н.Ганчимэг-ыг томилсугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын даргаар Б.Сүнчигмаа, гишүүнээр Г.Ганбат нарыг тус тус томилсугай.
10. Хувьцаа эзэмшигчдийн хурал зохион байгуулах комиссын даргаар Н.Ганчимэг-ийг томилон, хурал зохион байгуулахтай холбоотой зардлыг компаниас гаргахыг зөвшөөрч, хурал зохион байгуулах бэлтгэл ажлыг ханган ажиллахыг ТУЗ-ын нарийн бичгийн дарга Б.Эрдэнэтуяа нарт даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Н.ГАНЧИМЭГ